БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ЗОРИГТБАЯР

БАЯН-ӨНДӨР СУМЫН ГАНЦМОДОТ, ЖАРГАЛАНТ СУМЫН ДУЛААН-УУЛ БАГТ ГАДАРГЫН УС ХУРИМТЛУУЛАХ ХӨВ ЦӨӨРӨМ БАЙГУУЛАХ ЗУРАГ ТӨСӨЛ ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 12сарын 10-ны өдөр Дугаар 1 Баян-Өндөр сум

1	**Ажил гүйцэтгэх үндэслэл**	-Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт 6.3.10; -Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.17 дахь заалт; - Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
2	**Хөрөнгө оруулалтын эх үүсвэр**	Аймгийн ИТХ-ын 2025.12.04-ний өдрийн 02/58 дугаар тогтоолоор батлагдсан байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар
3	**Санхүүжилтийн хуваарь**	120,000,000 /Нэг зуун хорин сая/ төгрөг
4	**Захиалагч байгууллага**	Орхон аймгийн Байгаль орчны газар
5	**Байршил**	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ганцмодот, Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт Шувуутын аманд
6	**Ажлын зорилго**	Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нутаг дэвсгэрт газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах зураг төсөл боловсруулах.
7	**Ажлыг гүйцэтгэх хугацаа**	2026 онд хийгдэх ажил: - 2 байршилд зураг төсвийг 100 хувь гүйцэтгэнэ.
8	**Гүйцэтгэх ажлууд**	- Байр зүйн 1:1000 масштабтай инженер-геодезийн болон топографийн зураглал, инженер-геологийн судалгааны ажлыг холбогдох чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх; -Хөв цөөрөм (усан сан) байгуулах ажлын техникийн шийдлийг боловсруулж, ажлын тоо хэмжээ, тогтворжилтын тооцоог гүйцэтгэн, зураг төсөл боловсруулж, төсөв тооцоолох; - Хөв цөөрмийн эзлэхүүнийг зураг төсвөөр тооцон тодорхойлох; - Далангийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах хийцийн шийдэл, хэлбэр хэмжээг инженерийн тооцоонд үндэслэн тодорхойлох; - Хатуу урсацын, хагшаасны тооцоо хийх; - Ус өнгөрүүлэх барилга байгууламжийн хийц, хэлбэр хэмжээг тодорхойлох; - Болзошгүй үерийн аюулыг 1, 5, 10%-ийн хангамшилын зарцуулалтыг тодорхойлж, үерийн зардлыг 1%-ийн хангамшлаар тооцох;

		Баталгаажуулалт: - Хөв цөөрөм (усан сан) байгуулах зураг төсвийг Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэх; - Онцгой байдлын газраар зураг төсөлд дүгнэлт гаргуулах; - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар зураг төсөлд санал авч зөвшилцөх; - Шугам сүлжээний болон ашиглагч байгууллагуудтай зөвшилцөх;
9	**Гүйцэтгэгчид тавигдах шаардлага**	-Барилга хот байгуулалтын яамны "Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын тусгай зөвшөөрөл"-ийн 1.3.5 "Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах" тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага оролцох; - Төслийн багт мэргэжлийн гидротехникч 1, гидрогеологич 1, инженер геологич 1 тус бүр ажиллуулах;
10	**Ажлыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх хууль, барилгын норм, дүрмүүд**	**Монгол Улсын хуулиуд:** - Монгол Улсын Үндсэн хууль - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль - Усны тухай хууль; - Хамгаалалтын бүс тогтоох тухай; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Гамшгаас хамгаалах тухай хууль; - Галын аюулгүй байдлын тухай хууль; - Монгол Улсын Инновацийн тухай хууль; - Газрын тухай хууль; - Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Барилгын тухай хууль; **Норм, нормативууд:** БД 11-102-07 Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа БД 81-16-12 Зураг төслийн ажлын жишиг үнэ БД 81-106-11 Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм ЗГ-ын 2009 оны 204 дүгээр тогтоол, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоол, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм БНбД 33-01-03 Усны барилга, байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам БНбД 81-33-10 Усны барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм БНбД 81-95-12 Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 11-06-03Зургийн ерөнхий инженер (ерөнхий архитектор) -ийн дүрэм БНбД 11-07-04 Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНбД 11-03-01 Барилгын инженер геологийн ажил БД 81-105-11 Усны барилга байгууламжийн инженер, хайгуул судалгааны ажлын жишиг норм БНбД 12-01-09 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт БД 12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр

		хамгааллын үлгэрчилсэн заавар БНбД 11-08-06 Барилгын геодезийн ажил БНбД 3.01.06-90 Барилгын орчны тохижилтын ажил БНбД 3.02.01-90 Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил БНбД 33-03-05 Голын гидротехникийн барилга байгууламж БНбД 33-04-09 Усны барилга байгууламжийн буурь БНбД 33-05-09 Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл БНбД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтэц БНбД 3.05.04-90 Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж БНбД 40-102-06 Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төсөөлөх ба угсрах БНбД 40-02-06 Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНбД 3.04.03-90 Байгууламж ба барилгын бүтцийг зэврэлтээс хамгаалах БНбД 33-07-09 Шороон боомт БНбД 33-08-09 Бетон ба төмөр бетон боомт Бусад норм, норматив баримт бичиг, норм, дүрэм, заавар.
11	**Ажлын иж бүрдэл, тайлан ирүүлэх**	**Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч нь:** -Хөв цөөрмийн иж бүрэн ажлын зураг төсөл; - Материалын түүвэр, хөрөнгө оруулалтын тооцоо, төсөв; - Инженер-геологийн судалгааны ажлын тайлан; - Геодезийн судалгааны ажлын тайлан; - Бусад холбогдох материал. **Ажлын зураг төслийг хүлээлгэн өгөх:** - Ажлын зураг төсөл, төсвийг 5% */эх хувь 1, хуулбар 4/* үйлдэнэ. - Ажлын зураг төсөл, төсвийг pdf, dwg болон ажлын файл хэлбэрээр CD бичиж 5 хувь хүлээлгэн өгнө.
12	**Онцгой нөхцөл**	-Хөрсний ус, цэвдгээс хамгаалах арга хэмжээ; -Үерийн уснаас хамгаалах арга хэмжээ; -Газар хөдлөлтөөс үзүүлэх ачаалал, эрсдэлийг тооцсон байх; -Үерийн ус, халиа тошин үүсэхээс хамгаалах арга хэмжээг тооцох; -Хүн, мал осолдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх; -Усан сангийн орчимд гоц халдварт өвчинтэй сэг, зэм булшилсан эсэхийг сайтар нягтлах;
13	**Нэмэлт тайлбар**	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас “Хөв цөөрөм байгуулах” жил болгон зарлаасаатай холбогдуулан 333 сум - нэг хөв цөөрөм уриалгыг дэвшүүлсэн.

ХЯНАСАН:
АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА
С.ЖАРГАЛСАЙХАН

ЗӨВШИЛЦСӨН:
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Ж.БАТ-ӨЛЗИЙ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.БУЯНХҮҮ

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БӨГӨӨД "ХББЗА" ҮТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.НЭМЭХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН
П.ОДОНЧИМЭГ